



ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
тэмцэт бус 6 ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 08 сарын 04 өдөр

Дугаар 03

Зуунмод

“Нээлттэй Төв аймаг” хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Нээлттэй Төв аймаг” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Засаг дарга (Д.Мөнхбаатар)-д ДААЛГАХ нь:

2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө баталж, шаардагдах хөрөнгийг аймгийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусган, үр дүнд хяналт тавих

2.2. “Нээлттэй Төв аймаг” хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан мэдээлэх арга хэмжээг 2023 оны 09 дүгээр сард багтаан зохион байгуулах

2.3 Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоонд тулгуурлан хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 2025 оны 01 дүгээр улиралд багтаан танилцуулах

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нутгийн удирдлага, цахим хөгжлийн хороонд үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ЖАМБАЛСҮРЭН



4123010045

Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн
хурлын 2023 оны дугаар сарын-ны
өдрийн дугаар хуралдааныдугаар
тогтоолын хавсралт

“НЭЭЛТТЭЙ ТӨВ АЙМАГ” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа -2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг УИХ-аар батлуулан хэрэгжүүлж, Хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах зорилтын хүрээнд орон нутгийг хөгжүүлэх, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих зорилгоор “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 419 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны 56 дугаар тэмдэглэл гаргасан.

Мэргэжлийн байгууллагын судлаач, шинжээчид улс, аймгийн аймгийн хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлсийг тодорхойлон гаргасан бөгөөд манай аймгийн хувьд санхүүгийн хүртээмж, бүтээмж, байгалийн капиталыг сайжруулах шаардлагатай гэж тодорхойлсон бөгөөд аймгийнхаа хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлийн нөлөөллийг бууруулахын тулд хөдөө аж ахуйн салбарын түүхий эдийг боловсруулах, экспортод чиглэсэн, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрүүдийг байгуулах, байгальд ээлтэй, шууд ажлын байр бий болгодог аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилт дэвшүүлэн “Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөгөө”-г боловсруулан, батлуулж, эдийн засгийн 8 тойрогт хөгжүүлэх төслүүдийн зураг төсөл бэлэн болж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт татах таатай боломжийг бүрдүүлээд байна.

Аялал жуулчлалын чиглэлээр Манзушир шашин соёлын цогцолбор байгуулах төсөл, ТЭЗҮ-ийг боловсруулан, аймгийн төвд Археологи палентологийн музей байгуулж байна.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд манай аймагт үндэсний хэмжээний бүтээн байгуулалтууд буюу Хөшгийн хөндийн олон улсын онгоцны буудал, түүнийг дагасан бүтээн байгуулалт, дэд бүтэц шугам сүлжээ, Богд хан төмөр зам төсөл, Тээвэр логистикийн сүлжээ, Эдийн засгийн чөлөөт бүс, Шинэ Зуунмод хот байгуулах томоохон төслүүд хэрэгжиж, аймгийн эдийн засаг тэлэх “Эдийн засгийг тэтгэсэн бүтээн байгуулалтууд” эхэлж, шинэ бүтээн байгуулалт нэмж хийх нөхцөл бүрдүүлсэн Хөгжлийг тэтгэсэн дэд бүтцийн эх үүсвэр, өргөтгөл шинэчлэлийн ажлууд хийгдэж, манай аймагт хүн амын төвлөрлийг татах боломж бүрдээд байна.

Мөн Улаанбаатар хотын 22000 иргэн манай аймгийн газар нутагт газар эзэмшиж байгаа бөгөөд эдгээр газрын дэд бүтэц, цахилгаан эрчим хүчний асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэснээр шилжин ирэгсдийг тогтвортой суурьшуулах боломж нэмэгдэнэ.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээг өөрийн орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч, иргэдийн бэлэнчлэх сэтгэлгээнд өөрчлөлт оруулж, ажил, хөдөлмөр эрхлэхийн давуу тал, ач холбогдлыг ойлгуулах, өрхийн болон жижиг дунд үйлдвэр эрхлэх нөөц, боломж, хууль эрх зүйн орчныг сурталчлан, жижиг дунд үйлдвэрлэл болон өрхийн үйлдвэрлэлийг дэмжин хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн улмаар хотоос хөдөө рүү шилжих хөдөлгөөнийг дэмжсэн, аймаг, орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ, бүтээн байгуулалтыг дэмжсэн “Нээлттэй Төв аймаг” хөтөлбөрийг боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

2.1. Монгол Улсын хууль, хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох үндэсний хөтөлбөрүүд, аймаг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, эдийн засгийн чадавх, нийгэм болон байгаль орчны онцлог, орон нутгийн тогтвортой хөгжих бодлогод нийцсэн байх;

2.2. Аймаг орон нутагт шилжин ирж ажиллаж, амьдрах, үйл ажиллагаа эрхлэн явуулахад үүсэх давуу тал болон үүсэж болзошгүй хүндрэл бэрхшээлийг тооцсон бодлого хэрэгжүүлэх, мэдээллийг нээлттэй, тэгш, хүртээмжтэй түгээх;

2.3. Мэдээллийн тэгш, хүртээмжтэй байдлыг хангаж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хуулиар олгогдсон эрхийг дээдлэх, бизнес орчны тэгш боломж, шударга өрсөлдөөнийг бий болгох;

2.4. Иргэд олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, бизнесийн болон мэргэжлийн холбоодын оролцоог түлхүү дэмжих.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

3.1. Аймаг, орон нутгийн эдийн засаг, нийгмийн харилцааг сайжруулан, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, орон нутагт шилжин ирэгсдийн ажиллаж амьдрах орчин, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх замаар аймаг, сум орон нутгаа хөгжүүлэхэд оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Зорилт 4.1. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах, аж ахуйн нэгж байгууллагад үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэх;

4.1.1. Амьдрах таатай орчин бүрдүүлэх, хөгжлийг тэтгэсэн дэд бүтцийг өргөтгөх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

4.1.2. Зуунмод суманд 30 мВт-ын Дулааны станцыг ашиглалтад оруулах;

4.1.3. Дулаан, цэвэр, бохир усан хангамжийн 2-р хэлхээний шугам сүлжээний өргөтгөл шинэчлэл хийх;

4.1.4. 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 дэд станц барьж байгуулах;

4.1.5. Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 2, 3 дугаар

ээлжийн орон сууцны хороолол төслийг эрчимжүүлэх;

4.1.6. “Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууц” төслийг хэрэгжүүлэх;

4.1.7 Дулаан, цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээний хангамж бүхий нийтийн аж ахуйн цогц дэд бүтцийг сумдад байгуулж, иргэд ая тухтай амьдрах, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжүүлэх орчин бий болгох;

4.1.8. Хөдөө орон нутагт шилжин суурьшиж байгаа иргэдэд зориулсан орон сууцны зээл олгоход банкууд, зээлийн батлан даалтын сантай хамтран ажилллах;

Зорилт 4.2. Аймгийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх бодлого хэрэгжүүлэх;

4.2.1. Үндэсний томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхжүүлэх;

4.2.2. Олон улсын нисэх онгоцны буудал, Эдийн засгийн чөлөөт бүсийг түшиглэн байгуулагдах Зуунмод Үйлдвэр технологийн парк болон паркийг түшиглэн хөгжих үйлдвэрүүдийг байгуулах;

4.2.3. Аймгийн “Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлж, эдийн засгийн 8 тойрогт хөгжлийн төслүүдийг хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан дэмжин ажиллах;

- 1-р тойрог: Сэргэлэн, Алтанбулаг, Баян-Өнжүүл, Баянцагаан сумд: Үйлдвэрлэл, өндөр технологи, тээвэр логистик.
- 2-р тойрог: Эрдэнэсант, Өндөрширээт, Бүрэн, Дэлгэрхаан сумд: Мах бэлтгэл, тэжээлийн үйлдвэрлэлийн тойрог.
- 3-р тойрог: Лүн, Угтаалцайдам, Заамар сумдад: Газар тариалан, бэлчээрийн мал аж ахуйн тойрог.
- 4-р тойрог: Аргалант, Баянхангай, Баянцогт сумд: Мах, сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйн тойрог.
- 5-р тойрог: Цээл, Жаргалант, Сүмбэр сумд: Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх тойрог.
- 6-р тойрог: Баянчандмань, Борнуур, Батсүмбэр сумдад: Мах, сүүний эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх тойрог.
- 7-р тойрог: Эрдэнэ, Баяндэлгэр, Мөнгөнморьт сумдад: Аялал жуулчлал, органик хүнсний үйлдвэрлэл хөгжүүлэх тойрог.
- 8-р тойрог: Архуст, Баянжаргалан, Баян сумдад: Мал, мах түүхий эд бэлтгэлийг хөгжүүлэх тойрог

4.2.4. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг өндөр технологээр боловсруулж, экспортод чиглэсэн, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах;

4.2.5. Мах сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх эрчимжсэн цогцолбор аж ахуйг кластераар хөгжүүлэх;

4.2.6. Аялал жуулчлалын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж, аялал жуулчлалын салбарыг дагасан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох;

4.2.7. “Ногоон Төв аймаг” нөхөн сэргээлтийн төслийг хэрэгжүүлж, түүнд түшиглэсэн аялал жуулчлал, үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчин нөхцлийг бүрдүүлэх;

4.2.8. Аймгийн брэнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон

сурталчлах,

4.2.9. Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, жижиг дунд үйлдвэрийг байгуулж, боловсруулах салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

Зорилт 4.3. Ажлын байр нэмэгдүүлэх, мэргэжлийн ажиллах хүчний хомсдолыг багасгах, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн салбарын хүний нөөцийг бэхжүүлэх;

4.3.1. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхжүүлж аймагтаа ажлын байр нэмэгдүүлэх;

4.3.2. Аймаг, орон нутагт эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжлүүд болон хомсдолтой байгаа ажлын байруудыг нөхөх арга хэмжээ авах;

4.3.3. Эрүүл мэнд, Боловсрол, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц, барилга, аялал жуулчлал салбарт дутагдаж буй мэргэжлийн ажиллах хүчний судалгааг гаргаж, хангалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, дутагдалтай боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэх;

4.3.4. Төрийн албаны хүний нөөц бүрдүүлэх бүх төрлийн сонгон шалгаруулалтыг ил тод, шударга зохион байгуулж, сул орон тооны нөхөн хангалтыг нэмэгдүүлэх;

4.3.5. Ажилгүй иргэдийг байнгын, тогтвортой ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжин урамшуулж хамтран ажиллах;

4.3.6. Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехникийн коллежийг дэмжиж, орон нутгийн онцлог давуу талд түшиглэн, орон нутагт хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэх;

4.3.7. Орон нутагт нэн шаардлагатай хөдөө аж ахуйн мэргэжилтнийг тэтгэлэгт хөтөлбөрөөр бэлтгэн, хүний нөөцийг бүрдүүлэх;

Зорилт 4.4. Төрийн үйлчилгээнд цахим шилжилтийг эрчимжүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

4.4.1. “Цахим Төв аймаг” хөтөлбөртэй уялдуулан төрийн үйлчилгээг иргэдэд ойлгомжтой шуурхай болгож, олон нийтэд танилцуулах, ач холбогдлыг сурталчлах;

4.4.2. Аймаг, орон нутгийн онцлог давуу талыг сурталчлах нэгдсэн мэдээллийн санг /Huduu.mn/ бий болгож цахимжуулах;

4.4.3. Иргэд, хуулийн этгээдийн бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг цахимд шилжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон техник хэрэгслийн хүчин чадлын нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах;

4.4.4. Хотоос хөдөө рүү шилжин ирэхэд шууд болон дам нөлөөлдөг бэрхшээлийг бууруулахад чиглэсэн бодлогыг үе шаттай хэрэгжүүлж, боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

4.4.5. Төрийн зарим үйлчилгээнд иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх;

4.4.6. Хүн амын өсөлттэй уялдуулан нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийн амьжиргааг

дээшлүүлэх;

4.4.7. Шилжин суурьших гэр бүл, залуучуудад хөдөө амьдрах давуу тал, боломжуудыг сурталчлах, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах, иргэд, олон нийтийн сэтгэлгээ, хандлагад эерэг нөлөө үзүүлэх;

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг ажиллана. Ажлын хэсгийн ахлагч нь Монгол Улсын ерөнхий сайдын 157 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүн, аймгийн Засаг даргын орлогч байна.

5.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга батална. Ажлын хэсэг нь боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, газрын харилцаа, хэвлэл мэдээллийн болон санхүү, төсөв, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн ажилтны төлөөлөлтэй байна. Түүнчлэн УБ хот дахь нутгийн зөвлөл, бизнесийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачдын төлөөллийг зөвшилцлөөр оруулж болно.

5.3. Ажлын хэсэг аймгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулна.

5.4. Сум бүр өөрсдийн онцлогт тохирсон “Нээлттэй сум” үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллана.

5.5. Аймгаас мэдээллээ нээлттэй түгээх зорилгоор Улаанбаатар хот болон бүс нутгийн түвшинд зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаа, форум, хурал зөвлөгөөн, спорт, соёл урлагийн арга хэмжээнд оролцож аймгаа сурталчлан, ажлын үр дүн, тайланг Засаг даргын удирдлагын зөвлөл болон аймгийн ИТХурлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

5.6. Дэд ажлын хэсэг олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлах, үйл ажиллагааг Засгийн газрын дэргэдэх Ажлын хэсэгтэй хамтран нэгдсэн журмаар зохион байгуулах бөгөөд аймгийн нээлттэй мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, Төв мэдээллийн сантай мэдээлэл солилцох ажлыг орон нутаг дахь бүртгэл хариуцсан ажилтан шуурхай зохион байгуулна.

5.7. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад ажлын хэсгээс тогтмол хяналт тавьж, хэрэгжилтийг жил бүр дүгнэн хэлэлцэж, аймгийн Засаг дарга, ИТХ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнана.

Зургаа. Хэрэгжүүлэх хугацаа

6.1. Хөтөлбөрийн эхний шатыг 2023-2024 он дуустал хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

7.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

7.1.2. Хөгжлийн хөтөлбөрүүд, олон улсын байгууллагын тусламжийн хөрөнгө;

7.1.3. Хувийн хэвшлийн хандив, тусламжийн хөрөнгө;

7.1.4. Бусад.

7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу тухайн жилийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

8.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

8.1.1.Аймагт шилжин ирсэн иргэдийн бодит тоон өсөлт 10%-иас дээш нэмэгдсэн эсэх;

8.1.2.Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, бүтээн байгуулалт, аялал жуулчлал гэх мэт бүх төрлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн тоо-10-аас доошгүй;

8.1.3.Аймаг орон нутагт шинээр бий болсон ажлын байрны тоо-1500 ажлын байр;

8.1.4.Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний хэмжээ-13947.0 сая төгрөг

8.1.5.Иргэд, ААН байгууллагууд, олон нийт рүү чиглэж тэдгээрийг татах чиглэлээр зохион байгуулсан ажлууд, түүний үр дүн;

8.1.6.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлнэ.

8.2. Ажлын хэсэг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх зорилтот үзүүлэлтийг жил бүр тогтооно.

_____оОо_____